



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/261

Хэрлэн сум

### Ажил эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” 08 дугаар, 2025 оны “Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийг дүгнэх тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийн хөтөлбөр, төлөвлөгөө (2022-2032 он)-ний 2025 оны төлөвлөгөөт ажил, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлсүгэй.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг сар бүрийн 25-ны өдрийн дотор, нэгдсэн тайланг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Байгаль орчны газарт хүргүүлэхийг сумын Засаг дарга, төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3.Мэдээ тайланг нэгтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилж ажиллахыг Байгаль орчны газрын дарга (Б.Амгаланбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Баярхүү)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

